



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 09 дугаар сарын 14

Дугаар 16/05


Баян-Өндөр сум

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит XIV хуралдааны “Журам шинэчлэн батлах тухай” 14/05 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөл олгох, хугацаа сунгах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

Үйл ажиллагаагаа өргөжүүлэн, бие даан ажиллахаа илэрхийлэн холбогдох материалыг бүрдүүлж ирүүлсэн “Жаргалант гэрэлт амьдрал” сүмд үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг нэг жилээр олгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ